



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 18 өдөр

Дугаар А/645

Улаанбаатар хот

Нийслэлийн Нийтийн тээврийн газрын данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 11 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын тамгын газар болон Азийн хөгжлийн банк хамтран хэрэгжүүлсэн “Гэр хорооллын нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах техник туслалцааны төсөл”-ийн хүрээнд Бүгд найрамдах Солонгос Улсын “Цахим Ази ба мэдлэгийн түншлэлийн сан”-ийн буцалтгүй тусламжаар хандивласан нийт 510,732,000.00 (таван зуун арван сая долоон зуун гучин хоёр мянга) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг Нийслэлийн Нийтийн тээврийн бодлогын газар (Д.Отгонжаргал)-т зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн Нийтийн тээврийн бодлогын газар (Д.Отгонжаргал)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/40 дугаар тушаалын хавсралт

Бүртгэлд авах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн Нийтийн тээврийн бодлогын газар

Д/д	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Ашиглалт-тад авсан он	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэлийн анхны үнэ /төгрөгөөр/		Хөрөнгө оруулалтын шийдвэр болон хандивлагчийн нэр	Хөрөнгийн эх үүсвэр
							нэгжийн үнэ	нийт дүн		
1	Сервэр компьютер	Dell Power Edge R750 xs Rackmount	2024	сайн	ш	1	42,691,000.0	42,691,000.0	Азийн хөгжлийн банк болон Нийслэлийн Засаг даргын тамгын газар	Бүгд найрамдах Солонгос Улсын "Цахим Ази ба мэдлэгийн түншлэлийн сан"-
2	Ширээний Компьютер	Dell Optiplex 7090n MT	2024	сайн	ком	2	7,425,000.0	14,850,000.0		
3	Зөөврийн компьютер	Lenovo ThinkPad T490	2024	сайн	ш	1	4,994,000.0	4,994,000.0		
4	Сүлжээний хард диск	NAS: QNAP VS-2204 Pro+4-channel /2-bay/ HDMI /Tower Network Video Recorder	2024	сайн	ш	1	2,288,000.0	2,288,000.0	Азийн хөгжлийн банк болон Нийслэлийн Засаг даргын тамгын газар	Бүгд найрамдах Солонгос Улсын "Цахим Ази ба мэдлэгийн түншлэлийн сан"-
5	Тог баригч	APC BX1600MI-MS APC Back-UPS BX 1600 MI-MS, 900 Watts /1600 VA/ Nominal Input Voltage 230 V	2024	сайн	Ш	1	891,000.0	891,000.0		
6	Сүлжээний свич	Cisco Business CBS110-16T-D Unmanaged Switch 16 port	2024	сайн	ш	1	726,000.0	726,000.0		
7	Системийн хөгжүүлэлтийн модуль	DevExtreme Subscription	2024	сайн	ш	1	2,695,000.0	2,695,000.0	Азийн хөгжлийн банк болон Нийслэлийн Засаг даргын тамгын газар	Бүгд найрамдах Солонгос Улсын "Цахим Ази ба мэдлэгийн түншлэлийн сан"-
Тоног төхөөрөмжийн дүн							61,710,000.00	69,135,000.00		
8	Нийтийн тээврийн санал хүсэлтийн мэдээллийн систем		2024	сайн	ш	1	441,597,000.0	441,597,000		
Программ хангамжийн дүн							441,597,000.0	441,597,000.0		
НИЙТ БҮРТГЭХ ХӨРӨНГӨ							503,307,000.00	510,732,000.00		